

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 1(ТОЙМ)

Хуралдаан 2012 оны 1 дүгээр сарын 12 - ны өдрийн 14 цаг 15 минутанд эхэлж, 16 цаг 15 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 00 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	2011 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Булган аймагт зохион байгуулсан нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нь нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2011 оны 12 дугаар сарын 17-ны Булган аймагт зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. 2011 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Булган аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий 11 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д, нэр бүхий 7 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэснийг 1-2 дугаар хавсралтаар батлах,</p> <p>2.Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр</p>

		<p>бүхий 3 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 6 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3-4 дүгээр хавсралтаар батлах,</p> <p>3.Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр бүхий 9 иргэнийг тухайн албан тушаалд томилуулахыг Булган аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох,</p> <p>4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>"Төрийн удирдах албан тушаалтны манлайллын түвшинг үнэлэх ажлын удирдамж"-ийн тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1."Төрийн удирдах албан тушаалтны манлайллын түвшинг үнэлэх ажлын удирдамж"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Төрийн удирдах албан тушаалтны манлайллын түвшинг үнэлэх ажлын нэгдсэн хуваарь"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2.Тус удирдамжид заасан төрийн удирдах албан тушаалтны манлайллын шалгуур үзүүлэлтүүдийг хангах чиглэлээр салбар, нутаг дэвсгэр, байгууллагынхаа хэмжээнд тодорхой ажил төлөвлөн зохион байгуулж ажиллахын хамт манлайллын түвшинг үнэлэх ажлыг тогтоосон хугацаанд, чанартай гүйцэтгэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга нар болон төрийн болон төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдэд үүрэг болгох.</p> <p>3.Бүх шатны төрийн болон төсвийн</p>

		<p>байгууллагын ерөнхий менежерүүд, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга (менежер) нарын манлайллын түвшинд үнэлгээ өгөх ажлыг энэхүү удирдамжийн дагуу зохион байгуулж, дүнг 2012 оны 12 дугаар сард багтаан Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн Б.Батбаяр, Ажлын албаны дарга С.Цэдэндамба нарт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ-үнэлгээний газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд Лхамжавын Батжавыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Батсуурьт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын Барилгын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6-д заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын Барилгын хэлтсийн даргын албан тушаалд Цэдэн-Ишийн Төгсжаргалыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дарга Б.Лосолд санал болгох тухай Монгол Улсын Төрийн</p>

		албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргах тухай	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын Цөмийн материалын хэлтсийн даргын албан тушаалд Пүрэвдоржийн Баттөрийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын дарга С.Энхбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
6	Архангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1.Архангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Цолмонгийн Баясгаланбаатарыг томилох, 2.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 73 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 9-д “...Дамдингийн Данзан” гэснийг хүчингүй болсонд тооцох, 3.Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд чанд

		<p>нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Баясгаланбаатарт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	<p>Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар ажиллаж байсан Ж.Эрдэнэ-Очироос гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар ажиллаж байсан Ж.Эрдэнэ-Очироос Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2011 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн “Гомдлын тухай” 22 дугаар тогтоолыг эс зөвшөөрч, Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг хянан шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 болон Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.6-д заасныг удирдлага болгон :</p> <p>1.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн “Гомдлын тухай” 2011 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 22 тоот тогтоолыг үндэслэлтэй гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2.Ж.Эрдэнэ-Очирыг албан тушаал бууруулах энэхүү шийдвэрийнхээ дагуу тохирох албан тушаалд томилж ажиллуулахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүүд үүрэг болгох.</p> <p>3.Маргаан хянан шалгасан комиссын дүгнэлт, дүгнэлтийн тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлд болон иргэн Ж.Эрдэнэ-Очир нарт хүргүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

----oOo----